

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН
ЧУЛУУТ”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН” 2022
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

*Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-012439, MV-000213
Регистрийн дугаар:5935539*

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГазрын мэргэжилтэн:Ц.Жаргалнэмэх

Төв аймгийн БОАЖГазрын мэргэжилтэн:С.Эрдэнэцогт

Хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“Заамар Гоулд” ХХК-ний гүйцэтгэх захирал:.....С.Энхтулга

Төсөл хэрэгжүүлэгч, Биелэлтийг тайлагнасан:

“Юбиксолюшн” ХХК-ний захирал:.....Т.Эрдэнэсайхан

“Заамар Гоулд” ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн:.....Н.Гончигмаа

Агуулга

1. ОРШИЛ	5
2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	11
3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	11
3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	13
3.3. Газрын хэвлийн сөрө нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт	15
3.4. Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах аргууд.....	17
4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	18
5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
8. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	25
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	26
12. ДҮГНЭЛТ	27

Зургийн жагсаалт

Зураг 1 Тусгай зөвшөөрлийн талбайн байршил	7
Зураг 2 Талбай орчмын газрын гадаргын төлөв байдал	7
Зураг 3 Уурхайн ажилчдын хотхон	8
Зураг 4 Засварын талбай орчим төлөв байдал	9
Зураг 5 Уурхайн шатах тослох материалыны агуулах	10
Зураг 6 Орд орчмын төлөв байдал	10
Зураг 7 Усалгааны ажил хийгдэж буй байдал	11
Зураг 8 Уурхайн хотхонд агаарын хэмжилт хийж буй байдал	12
Зураг 9 Олборлолтын талбай дахь хэмжилтийн байдал	12
Зураг 10 Засварын талбайд агаарын хэмжилт хийж буй байдал	12
Зураг 11 Цэврийн нуурнаас дээж авч буй байдал	13
Зураг 12 Цэврийн нууранд дахь галуу шувууд	14
Зураг 13 Бохирын нуурнаас дээж авч буй байдал	14
Зураг 14 Худгийн тоолуур	14
Зураг 15 Шимт хөрсний овоолго ба Шимт хөрснөөс дээж авч буй байдал	15
Зураг 16 ШТС-ийн орчмоос хөрсний дээж авч буй байдал	16
Зураг 17 Тос, масло солих газрын хөрсийг хамгаалсан байдал	17
Зураг 18 Сургалтын явц	18
Зураг 19 ШТС-ын галаас хамгаалах багаж байрлуулсан	18
Зураг 20 Дотоод овоолго үүсгэх замаар нөхөн сэргээлтийн ажил хийгдэж буй байдал	19
Зураг 21 Ухшийг дүүргэх, хурдас чулуулгийн овоолгыг намсгах, ирмэгийг налуулах, тэгшлэх, хэлбэршүүлэлтийн ажил явагдаж байна.	20
Зураг 22 Нөхөн сэргээсэн талбай дахь ургамалжилтийн мониторинг хийж буй байдал	20
Зураг 23 Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хашаалалт	21
Зураг 24 Хог хаягдлын сургалтын явц	23
Зураг 25 Хогийн сав- хогоо ялган ангилсан байдал	23
Зураг 26 Тамир-ЭМ бэлдмэлийг хэрэглэх заавар	24

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол /МУ-000213/ 34.43 га	6
Хүснэгт 2 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол /МУ-012439/ 152.53 га	6
Хүснэгт 3 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт	11
Хүснэгт 4 Усан орчны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт	13
Хүснэгт 5 Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт	15
Хүснэгт 6 Ургамал амьтны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт	17
Хүснэгт 7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт	21
Хүснэгт 8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт	26
Хүснэгт 9 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	27

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1 Ус ашиглах зөвшөөрөл	28
Хавсралт 2 Ус ашиглах дүгнэлт.....	29
Хавсралт 3 Усны дээж шинжилгээний дүн /5 сар/.....	39
Хавсралт 4 Усны шинжилгээний дүн /8 сар/.....	40
Хавсралт 5 Ус ашиглах гэрээ	41
Хавсралт 6 Засварын талбай дахь хөрсний дээжний шинжилгээний дүн /5 сар/.....	44
Хавсралт 7 ШТС-ын хөрсний дээж шинжилгээний дүн /5сар/.....	45
Хавсралт 8 Шимт хөрсний дээж шинжилгээний дүн /5 сар/	46
Хавсралт 9 Хөрсний шинжилгээний дүн /8 сар/	47
Хавсралт 10 Агаарын дүн шинжилгээний хариу	48
Хавсралт 11 Нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр төлсөн баримт	49
Хавсралт 12 Хаягдал усны дүгнэлт	50

1. ОРШИЛ

Монгол Улсын байгаль орчны тухай хууль, журмын дагуу төсөл хэрэгжүүлэгч нь аливаа үйл ажиллагаа эхлүүлэхийн өмнө байгаль орчны суурь судалгаа, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний ажлуудыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, үнэлгээнд тусгагдсан байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдөн ажиллах үүрэгтэй.

Энэхүү үүргийнхээ хүрээнд манай компани нь байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, байгалийн унаган төрхийг аль болох хадгалах, биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу өндөр түвшинд хийж гүйцэтгэх бодлого баримталж, байгаль орчны бодлого зорилтод нийцсэн арга хэмжээнүүдийг авч, биелэлтийг ханган ажилладаг. Үүнд:

- Байгаль орчны бохирдолтоос сэргийлэх, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг тодорхойлж, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг авах зорилгоор байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хийлгүүлэх
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, тогтоомж холбогдох дүрэм журам стандартыг дагаж ажиллах
- Олборлолт болон уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчны асуудлыг тусган хэрэгжүүлэх хамаарна.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь тус оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний заалтуудыг ханган ажиллахад чиглэсэн болно.

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Цагаан чулуут нэртэй MV-000213, MV-012439 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос баруун хойш 200 км, Төв аймгийн Заамар сумын төвөөс баруун хойш 20 км, “Шижир алт” суурингаас 15 км зайд, байр зүйн зургийн М-48-138 нэрэлбэрт орших ба талбайн булангийн цэгүүдийн газар зүйн солбилцолыг хүснэгтээр үзүүлэв. Бүс нутгийн хувьд Хэнтийн нурууны баруун хойд хэсэгт, Заамарын нуруу, Туул голын ай сав газарт, дэд бүтцийн тааламжтай нөхцөлд байрладагаараа онцлогтой.

Төв аймгийн Угтаал, Цээл, Лүн сум Булган аймгийн Баян нуур, Бүрэгхангай, Сэлэнгэ аймгийн Орхон туул сумтай хиллэж нийт 280.3 мянган га нутаг дэвсгэртэй. Газар тариаланг эрчимтэй чиглэлээр хөгжүүлэхэд тохиромжтой бөгөөд бүх нутгийн 60 шахам хувийг малын бэлчээрт ашиглах боломжтой байсан бол одоо 30 орчим хувийг мал аж ахуйн бэлчээрт ашиглаж байна. Нүүрс, төмрийн хүдэр, алт, зэс төрөл бүрийн болор гялтагнуур, хужир шүү элбэгтэй. Цайдам, Баржин, Хайлаастай зэрэг үе мөч, дотрын өвчнийг анагаахуйц рашаан устай.

Хар, хар хүрэн ойн үнсэнцэр хөрстэй, талбай орчмын хөрсөн бүрхэвч уулын хүрэн шороон хөрсийг карбонаттай, хархүрэн, хүрэн, цайвар, нугархаг хэмээн таван дэд хэв шинжид ангилдаг. Талбай орчмын хөрс нь хар хүрэн ангилалд хамаарч байгаа юм.

Ургамлын байгалийн бүс бүслүүрийн ангиллын хувьд Заамар сумын нутаг нь цөлийн хээр, өндөр уулын, уулын ойт хээр, уулын хээр, бэлчээрийн бус, хээр ба хуурай хээр гэсэн ангилалд хамаарна.

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМИН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН


Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол /МУ-000213/ 34.43 га

Д/д	Уртраг	Өргөрөг
1	104° 33' 34.05"	48° 18' 35.05"
2	104° 33' 34.2"	48° 18' 17.57"
3	104° 33' 38.57"	48° 18' 17.58"
4	104° 33' 38.61"	48° 18' 12.41"
5	104° 33' 42.48"	48° 18' 12.42"
6	104° 33' 42.6"	48° 17' 58.18"
7	104° 33' 32.91"	48° 17' 58.14"
8	104° 33' 32.79"	48° 18' 12.38"
9	104° 33' 28.42"	48° 18' 12.36"
10	104° 33' 28.38"	48° 18' 17.54"
11	104° 33' 24.97"	48° 18' 17.53"
12	104° 33' 24.79"	48° 18' 40.26"
13	104° 33' 37.4"	48° 18' 40.26"
14	104° 33' 37.44"	48° 18' 35.06"

Хүснэгт 2 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол /МУ-012439/ 152.53 га

№	Уртраг			Өргөрөг			№	Уртраг			Өргөрөг		
1	104°	33'	26.58"	48°	18'	56.82"	15	104°	33'	34.2"	48°	18'	17.57"
2	104°	33'	21.02"	48°	18'	56.82"	16	104°	33'	38.57"	48°	18'	17.58"
3	104°	33'	21"	48°	17'	51.82"	17	104°	33'	38.61"	48°	18'	12.41"
4	104°	33'	46.01"	48°	17'	51.82"	18	104°	33'	42.48"	48°	18'	12.42"
5	104°	33'	46.01"	48°	17'	22.83"	19	104°	33'	42.61"	48°	17'	58.18"
6	104°	34'	16"	48°	17'	22.83"	20	104°	33'	32.91"	48°	17'	58.14"
7	104°	34'	16"	48°	17'	51.82"	21	104°	33'	32.79"	48°	18'	12.38"
8	104°	34'	1.01"	48°	17'	51.82"	22	104°	33'	28.42"	48°	18'	12.36"
9	104°	34'	1.02"	48°	18'	33.83"	23	104°	33'	28.38"	48°	18'	17.54"
10	104°	33'	43.02"	48°	18'	33.83"	24	104°	33'	24.97"	48°	18'	17.53"
11	104°	33'	43.02"	48°	18'	40.29"	25	104°	33'	24.78"	48°	18'	41.16"
12	104°	33'	37.4"	48°	18'	40.29"	26	104°	33'	29.15"	48°	18'	41.19"
13	104°	33'	37.44"	48°	18'	35.06"	27	104°	33'	29.06"	48°	18'	51.21"
14	104°	33'	34.05"	48°	18'	35.05"	28	104°	33'	26.63"	48°	18'	51.2"

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМИН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 1 Тусгай зөвшөөрлийн талбайн байршил



Зураг 2 Талбай орчмын газрын гадаргын төлөв байдал

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМИН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 3 Уурхайн ажилчдын хотхон

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМИН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 4 Засварын талбай орчим төлөв байдал



Зураг 5 Уурхайн шатах тослох материалыны агуулах



Зураг 6 Орд орчмын төлөв байдал

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Заамар Гоулд” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх үүрэгтэй.

3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт 3 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд утааны шүүлтүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос маслыг тогтоосон хугацаанд нь солих	Уулын мастер	250 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийн тос, маслыг сольж байсан.
2.	Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг тогтмол услах		Зам усалгааны ажлыг тогтмол хийж гүйцэтгэж байсан.
3.	Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлэх	Уурхайн дарга	Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээг хийлгэсэн ба шинжилгээний дүнг хавсаргав.
4.	Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, хөрс тоос салхинд хийсч агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх		Тэмдэг, тэмдэглэгээ уурхайн дотоод замыг сайжруулан засч, салаа зам гаргахгүй байх зааварчилгааг өгч ажилласан
5.	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө.		Тээврийн хэрэгслийн төлбөр, татварыг бүрэн төлж ажилласан.



Зураг 7 Усалгааны ажил хийгдэж буй байдал



Зураг 8 Уурхайн хотхонд агаарын хэмжилт хийж буй байдал



Зураг 9 Олборлолтын талбай дахь хэмжилтийн байдал



Зураг 10 Засварын талбайд агаарын хэмжилт хийж буй байдал

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Усны нөөцийг хамгаалах үүднээс технологит ашиглах усны хэмжээг бага байлгах үүднээс анхаарч ажилласан. Баяжуулах буюу элстэй шороог угаахад хэрэглэж буй усыг 30%-ийг сэлбэн 70%-ийг эргүүлэн ашигласан.

Хүснэгт 4 Усан орчны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Сав газартай гэрээ байгуулан ус ашиглах дүгнэлт гаргуулах	Компаний захирал	Сав газартай байгуулсан гэрээ болон ус ашигласан төлбөр төлсөн баримтаа хавсаргав.
2.	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Байгаль орчны мэргэжилтэн	Шинжилгээний хариу шалгуур үзүүлэлт нь хавсралтад тусгагдав.
3.	Унд ахуйн усанд эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийг тогтоож бүсэд мөрдөх журмыг сахин ажиллах		Бүсэд мөрдөх журмыг боловсруулан, нийт ажилчдад танилцуулсан.
4.	Уурхайн унд ахуйд хэрэглэж буй худагт тоолуур тавих	Байгаль орчны мэргэжилтэн	Унд ахуйд хэрэглэж буй уст цэгтээ тоолуурж тавьж, орон нутгийн байгаль орчны байцаагчаар акт үйлдүүлэн баталгаажуулан ажилласан.
5.	Хаягдал ус зайлуулах гэрээ болон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах	Байгаль орчны мэргэжилтэн	Хаягдал усны төлбөрийн баримт, хаягдал ус зайлуулах дүгнэлт хавсаргав



Зураг 11 Цэврийн нуурнаас дээж авч буй байдал



Зураг 12 Цэврийн нууранд дахь галуу шувууд



Зураг 13 Бохирын нуурнаас дээж авч буй байдал



Зураг 14 Худгийн тоолуур

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

3.3. Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

Хүснэгт 5 Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Газар эзэмших гэрээгээ Заамар сумын ЗД-тай байгуулах, төлбөрөө төлөх	Компанийн захирал	Гэрээ болон төлбөр төлсөн баримтаа хавсаргав.
2.	Уулын ажлын төлөвлөгөөр 2022 онд 4 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийх	Байгаль орчны мэргэжилтэн, уулын мастер	Нөхөн сэргээлтээ сум орон нутагт хүлээлгэн өгсөн тухай акт хавсаргав.
3.	Хуулсан шимт хөрсийг хадгалж хамгаалах	Байгаль орчны мэргэжилтэн	Шимт хөрсийг хэлбэршүүлэн хадгалсан бөгөөд 2022 онд шимт хөрсийг ашиглах учраас ургамалжуулах ажил хийгдээгүй.
4.	Засварын газраас өөр газарт тос, масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж, саармагжуулан бохирдсон хөрсийг авч зайлуулах	Байгаль орчны мэргэжилтэн	Засварын талбайгаас өөр газарт тос, масло асгарсан тохиолдол бүртгэгдээгүй ба саармагжуулах бүтээгдэхүүнүүд бэлэн байгаа билээ.
5.	Тоног төхөөрөмжийн тос масло солих газрын хөрсийг хамгаалах	Байгаль орчны мэргэжилтэн	Хамгаалах талбайг бэлтгэн, асгаралтын үед шаардагдах элс, шингээгч материалуудыг ойр байршуулсан.



Зураг 15 Шимт хөрсний овоолго ба Шимт хөрснөөс дээж авч буй байдал

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМИН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 16 ШТС-ийн орчмоос хөрсний дээж авч буй байдал

<p>1</p>	<p>2</p>	<p>3</p>
<p>4</p>	<p>5</p>	<p>1. Засварын талбайд ашигласан тос, маслыг хадгалах 9м² бүхий талбайг бэлтгэсэн.</p> <p>2. Ашиглагдсан тос, масло хөрсөнд нэвчин гүний ус, уст давхаргыг бохирдуулах болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэхийн тулд доторжуулан тусгаарлагч материалыг дэвсэж байна.</p> <p>3. 4. Гадаргуу дээрээ бохирдуулагчийг шингээгч материал болох нарийн ширхэг бүхий эфилиэр гадаргууг бүрхэн тэгшилсэн.</p> <p>5. Бэлэн болсон ашигласан тос, масло хадгалах цэг</p>
<p>6. Засварын талбайд шинэ тос, маслыг хадгалах 36м² бүхий талбайг бэлтгэсэн.</p>	<p>7. Тос, масло хөрсөнд нэвчин гүний ус, уст давхаргыг бохирдуулах болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэхийн тулд доторжуулан тусгаарлагч материалыг дэвсэж байна.</p>	<p>8. Гадаргуу дээрээ бохирдуулагчийг шингээгч материал болох нарийн ширхэг бүхий эфилиэр гадаргууг бүрхэн тэгшилсэн.</p>

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМИН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 17 Тос, масло солих газрын хөрсийг хамгаалсан байдал

3.4. Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах аргууд
Хүснэгт 6 Ургамал амьтны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Олон салаа зам гаргахгүй байх	Уурхайн дарга, Байгаль орчны мэргэжилтэн	Өглөө бүрийн ажлын зааварчилгаанд заавар өгдөг. Уурхайн бүсэд мөрдөх байгаль орчны 7 дүрэм, зарчмыг боловсруулан, даган мөрдүүлэх тал дээр ажиллаж байна.
2.	Уурхайн ажилчдад Хог хаягдал ангилах ач холбогдол сургалт зохион байгуулна.	Байгаль орчны мэргэжилтэн	Сургалтын явц болон гарсан үр дүн /ангилсан хаягдлаа тушаах
3.	Нөхөн сэргээлт хийсэн талбайд ургамлын бичиглэл хийнэ.	Байгаль орчны мэргэжилтэн	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайдаа ургамлын бичиглэлийг хийсэн.
4.	Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байршуулах	ХАБЭА-н ажилтан	Гал унтраах багаж хэрэгслүүдийг байрлуулж ажилласан



Зураг 18 Сургалтын явц



Зураг 19 ШТС-ын галаас хамгаалах багаж байрлуулсан

4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 онд **8.5 га** талбайд уулын ажил явагдсан. Уурхайн ашиглалтын ажил явагдаж байхад нөхөн сэргээлт буюу дүүргэлтийн ажлыг дотоод овоолгоор зэрэгцээ байдлаар хийдэг. Энэ нь нөхөн сэргээлтийн зардлыг багасгах болоод их хэмжээний гадаад овоолгыг үүсгэн, газрын эвдрэл үүсгэхгүй байх давуу талтай.

Дотоод овоолгоор олборлолт явуулсан талбайн **4.0 га**-д техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөөд байсан бол **6.0 га** талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байна. Техникийн нөхөн сэргээлтийг хийх ихэнхи зардал нь ашиглалтын зардалд шингэх бөгөөд биологийн нөхөн сэргээлт хийх үед ахин хэвгийжүүлэх дагтаршуулах, шимт хөрсийг дэвсэх ажлууд

хийгдэнэ. Уурхайн ашиглалтын явцад уулын ажилтай зэрэгцүүлэн дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийх бөгөөд угаагдсан эфель гаалийг буцаан тээвэрлэж нөхөн дүүргэлт хийсэн.

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 1000 ширхэг мод тарихаар төлөвлөөд байсан бол ажилчдын хотхон орчимд **1200 ширхэг** 2-3 настай хайлаас модны суулгацаар тарилт хийж, арчлалт хамгаалалтын ажлыг хийсэн.



Зураг 20 Дотоод овоолго үүсгэх замаар нөхөн сэргээлтийн ажил хийгдэж буй байдал



Зураг 21 Ухшийг дүүргэх, хурдас чулуулгийн овоолгыг намсгах, ирмэгийг налуулах, тэгшлэх, хэлбэршүүлэлтийн ажил явагдаж байна.



Зураг 22 Нөхөн сэргээсэн талбай дахь ургамалжилтийн мониторинг хийж буй байдал



Зураг 23 Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хашаалалт

5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгаас тогтоож өгсөн 5.7 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж хүлээлгэн өгсөн.

Д/д	Х	Ү
1	104 31 31.85	48 23 15.57
2	104 31 18.19	48 23 21.44
3	104 31 22.32	48 23 26.27
4	104 31 29.38	48 23 26.06

6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй.

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны олборлолтын явцад ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл олдоогүй болно.

8. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 онд осол эрсдэлгүй ажилласан байна. Ажилчдын дунд “Тэг Осол эрсдэлгүй ажлын байр” нэртэй уралдааныг сар бүр зохион байгуулж байгаа бөгөөд ажлын хэсэг тус бүрээс шилдэг ажилчдыг урамшуулдаг. Хөдөлмөр аюулгүй байдлын сургалт, өдөр тутмын зааварчилгааг ХАБ хариуцсан мэргэжилтэн өгч байгаа билээ.

9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйл ажиллагааны явцад гарах ахуйн хог хаягдлыг Заамар сумтай гэрээ байгуулан тээвэрлүүлсэн. /Төлбөр төлсөн баримт хавсаргав/ Мөн байгальд шууд хаягдах хаягдлын хэмжээг багасгахын тулд эх үүсвэр дээр нь ялган ангилалт хийх хогийн савыг уурхайн хотхон байрлуулан, ялган ангилалт хийж, ажилчдад хог хаягдлын хор уршиг болон ялган ангилалтын үр ашгийн талаарх сургалтуудыг орсон.

Хүснэгт 7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Зарим хаягдлыг нэгдсэн журмаар сумын хогийн цэгт хаях	Компанийн захирал	Засаг даргатай хийсэн гэрээг хавсралт хэсэгт оруулав.
2.	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ.		

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

3.	Ахуйн шингэн хаягдал гүний усыг бохирдуулж байгаа эсэхэд бохир усны химийн шинжилгээ хийлгэх	Байгаль орчны мэргэжилтэн	Хяналт шинжилгээний ажлаар гүний худагнаас усны дээж авч шинжилгээнд өгсөн ба шинжилгээний дүнг хавсралтад оруулав. Хаягдал усны гэрээ, дүгнэлтийг гаргуулсан бөгөөд хаягдал ус зайлуулах зөвшөөрөлтэй.
4.	Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдан авах		Ахуйн бохироо Тамир-ЭМ бэлдмэлээр ариутган халдваргүйжүүлэн, задалдаг. 2022 онд 50ш Тамир Эм бэлдмэл авч хэрэглэсэн.
5.	Уурхайн техникт ашигласан тос, маслыг хаягдал тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэх		Одоогоор хаягдал тосыг цуглуулах ажил хийгдэж байгаа бөгөөд “Алтан Оршихуй” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна..
6.	Ахуйн хатуу хог хаягдлаа ангилах хогийн савнуудыг байрлуулах		Уурхайн хотхонд хуванцар сав, шил болон лааз, цаасан хаягдлуудыг ялгах тасалгаа бүхий тагтай сав хаягдал төмөр ашиглан хийж, байрлуулсан.
7.	Хаягдлаас гарах дахин ашиглагдах түүхий эдийг ялгах		Ялган ангилаад хурааж байна.



Зураг 24 Хог хаягдлын сургалтын явц



Зураг 25 Хогийн сав- хогоо ялган ангилсан байдал

Ажилчдын шингэн хог хаягдлыг ариутгах журмаар “Тамир-ЭМ” бэлдмэлийг ашигласан бөгөөд уурхайн үйлчлэгчид хэрэглэх зааварчилгааг хүргэсэн.



Ил задгай жорлон, бохирын цэвэрлэгээнд 1-2л Тамир-ЭМ-ийг жил бүрийн хавар 5-6 сард, зун 8-9 сард 2 удаа хийнэ. Ингэснээр үнэрийг дарж, бохирыг ширгээж, ялгадсыг био яламаг болгон хөрсийг эрүүлжүүлэн 00-ын эдлэх хугацааг уртасгадаг.

Тамир био бэлдмэлийг ашиглах заавар:

- Ашиглахаас өмнө сайтар сэгсэрнэ.
- 1 м3 жорлонгийн агууламжинд 1 литр Тамир ариутгагч байхавар тооцож 8-10 литр хлоргүй бүлээн усанд шингэлж жорлонгийн нүхний нэг булан руу цутгана.
- Хэрэв жорлонгийн бохир ус ихтэй бол Тамир био ариутгагчийг усвар шингэлэхгүйгээр шууд нэг булан руу нь цутгана.

АНХААРААРАИ: Хлор нь амьд биетийг устгагч хорт бодис тул био бэлдмэлийг шингэлэхдээ хлортой ус ашиглавал бэлдмэлийн үйлчилгээнд муу нөлөөтэй. Ус нь хлортой байх магадлалтай тул усав саванд хийж 2 хоног жонуулахад хлор нь ууршиж алга болно. Ингэж хлоргүйжсэн усыг био бэлдмэл шингэлэхдээ ашиглаарай.

Зураг 26 Тамир-ЭМ бэлдмэлийг хэрэглэх заавар

ЭМ технологийг хэрэглэхэд гарах үр дүн

- Хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бичил биетнүүдийг дарангуйлж хөрсийг эрүүлжүүлнэ.
- Ургамалд хүртээмжгүй органик ба эрдсийн нэгдлийг хүртээмжтэй хэлбэрт шилжүүлнэ.
- Хүлэмжийн хөрсийг солихгүйгээр олон жил хэрэглэх боломжтой.
- Хөрсний уусмалын концентрацийг бууруулна.
- Ургамлыг олонх мөөгөнцөрийн өвчин болон тохиромжгүй нөхцлийг тэсвэрлэх чадварыг нь дээшлүүлнэ.

Уурхайн эмнэлгээс гарах аюултай хаягдлыг Заамар сумын Эрүүл Мэндийн төвд нийлүүлэн, хамтран ажиллах гэрээ байгуулан тогтсон хугацаанд хаягдлыг хүргэж, хаягдлыг бүрэн зайлуулах хүртэл аюулгүй нөхцөлд түр цуглуулан, хаягдалд хяналт тавин ажиллаж байна.

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус оны 5 сард “Газарчандмань” ХХК, 8 сард “Ногоон Эко Мандала” ХХК-аар тус тус хийлгүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд хөрс, уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж мөн агаар дахь тоосжилтын хэмжээ болон дуу, чимээ, харьцангуй чийгшил зэрэг үзүүлэлтүүдийн хэмжилтийг хийсэн.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон төслийн үйл ажиллагаанд дараах үндсэн ач холбогдолтой. Үүнд:

- Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрт эрт илрүүлэх
- Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
- Хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хийлгэн төр захиргааны байгууллагууд болон төсөл хэрэгжих орон нутгийн оршин суугч, иргэдэд танилцуулж байх нь төслийн цаашид тогтмол хэрэгжих нөхцлийг бүрдүүлэх юм.

“Заамар Гоулд” ХХК-ийн Цагаан чулуутын гүний дарагдмал алтны шороон ордыг ил аргаар ашиглах бөгөөд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж буй өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах зорилгоор жил бүр хяналт шинжилгээний ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлдэг.

Хяналт шинжилгээний дээж	Хяналт шинжилгээний үзүүлэлт	2022 оны хяналт шинжилгээний хэлбэр, зардал	Хяналт шинжилгээ явуулах хугацаа	Хяналт шинжилгээ явуулах байршил	Хяналт шинжилгээ хийх багаж, холбогдох стандарт
Агаар	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ CO -ын агууламж, дуу чимээ	Агаарын шинжилгээний 3 цэгт жилд 2 удаа хэмжилт хийлгэнэ. 1 цэгт нэг удаагийн хэмжилт	Жил бүрийн 5 болон 8 дугаар саруудад	Уурхайн карьер, Уурхайн зам, Ажилчдын хотхон	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар-хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2016
Ус	Ажилчдын унд ахуйд ашигладаг усыг бактериологи болон ундны усны ерөнхий шаардлага, цэврийн болон бохирын нуурын усыг гадаргын ус болон хүнд металлын	Унд ахуйн ус Бактериологи - Усны химийн ерөнхий шинжилгээ Цэврийн болон бохирын нуур Хүнд металл	Жил бүрийн 5 болон 8 дугаар саруудад	Унд ахуйн усны гүний худаг, цэврийн болон бохирын нуур	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус, Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2018, Байгаль орчны аялал жуучлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 04 сарын 05 өдрийн А82/128 тоот тушаалын хавсралт. Ахуйн

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТ”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

	шинжилгээнд өгөх				хаягдал ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам
Хөрс	Хөрсний агрохими болон хүнд металлын шинжилгээ хийлгэх мөн тухайн газар дээр хөрсний температур хэмжих	Шимт хөрсний овоолго Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай Засварын талбай Шатахуун түгээх газар	Жил бүрийн 5 болон 8 дугаар саруудад	Уурхайн шимт хөрсний овоолго, ахуйн бохир усны хаягдал орчимд, нөхөн сэргээсэн талбай, эвдрээгүй газар	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр. төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох MNS2305-94 Дээж авах. савлах. тээвэрлэх. хадгалах журам MNS(ISO) 4814:1999. Атом Шингээлтийн Спектрметрээр шинжилгээ хийх

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцаж ажиллана.

Хүснэгт 8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Компанийн захирал Байгаль орчны мэргжилтэн	Байгаль орчны бодлого хөтөлбөр, хяналт шинжилгээ хийх журам, хог хаягдлын цуглуулах, хадгалах ажлын тухай заавар журмуудыг захирлаар батлуулж, ажилчдад танилцуулан дагаж мөрдөн ажиллаж байна.
2.	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтэнгүүдийг газар дээр нь танилцуулна.		Заамар сумын Хайлааст багийн иргэдийн нийтийн хуралд уурхайн үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн талаар илтгэл хэлэлцүүлсэн.
3.	Техник болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайг сум орон нутаг болон улсын комисст хүлээлгэн өгөх		Улсын комисст хүлээлгэн өгсөн актыг хавсралтад оруулав.
4.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Заамар сумын ЗДТГ-т хүргэн өгч байх		Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон тус оны нөхөн сэргээлт, нийгмийн хариуцлагын тайланг хүргэн танилцуулдаг.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нэгдсэн төсөв

Хүснэгт 9 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

№	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	4 000.0
2	Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	1 400.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	5 000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Нөхөн сэргээлтийн зардал	7 500.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1 496.8
7	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	1 000.0
8	Түүх соёл шинжлэх ухааны дурсгалт зүйлд зарцуулах болзошгүй зардал	500.0
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт зардлын дүн		20 896.8

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт төгрөг 20,896,800 төг зарцуулахаар төлөвлөөд байна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тус зардлыг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалт зүйлийн дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 50% болох 10,448,400 төгрөг байршуулсан.

12. ДҮГНЭЛТ

2022 оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу 8.5 га талбайд уулын ажил явагдсан. Дотоод овоолгоор олборлолт явуулсан талбайн 4.0 га-д техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөөд байсан бол 6.0 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байна.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус оны 5 сард “Газарчандмань” ХХК, 8 сард “Ногоон Эко Мандала” ХХК-аар хийж гүйцэтгүүлээ. Энэхүү хяналт шинжилгээний хүрээнд уурхайн технологийн ус болон цэвэр усны нууранд гадаргын усны чанар стандартад нийцэж байгаа эсэхэд бохирын нуурны усанд хүнд металлын үзүүлэлт, агууламж хэдий хэмжээтэй байгааг итгэмжлэгдсэн лабораториудад дээж өгч шинжлүүлэн өмнөх сарын үр дүнтэй харьцуулж үзсэн. Тус шинжилгээний дүнгээр цэвэр нуурын ус гадаргын усны стандартад шаардлагын түвшинд, бохирын нуурын хүнд металлын агуулга стандартаас хэтрээгүй үзүүлэлттэй байсан. Уурхайн ундны филтэртэй, филтэргүй ундны усны стандартад нийцэж байгаа эсэх, мөн бактерлогийн шинжилгээ хийлгэсэн. Тус шинжилгээний үр дүнд Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2005 стандартын хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт илрээгүй стандартын шаардлага хангаж байгаа филтэртэй усыг унданд хэрэглэх нь илүү зохимжтой. Уурхайн засварын газар, ШТС-ын ойролцоо газрын хөрсөнд хүнд металлын шинжилгээ хийлгэсэн бөгөөд стандарт түвшинд байна.



ТУУЛ ГОЛЫН САВ
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1, 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, “Усны газар”-ын 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 05/161 дугаартай албан бичгээр ирүүлсэн Дугаар 13 “Ус ашиглуулах дүгнэлт”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-012439, MV-000213 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Цагаан чулуут” нэртэй алтны шороон ордоос 196'920.0 м³ элс угаах үйлдвэрлэл, технологийн болон бусад хэрэглээнд зарцуулах 73'665.0 м³ усыг “Юбиксолюшн” ХХК-ийн эзэмшлийн 2 худгаас, унд-ахуйн хэрэглээний 2'349.0 м³ усыг өөрийн эзэмшлийн 1 худгаас 2022 онд ашиглахыг “Заамар гоулд” ХХК-д зөвшөөрсүгэй.

Хоёр. Ус ашиглагчтай гэрээ байгуулах, ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд хяналт тавьж ажиллахыг Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах алба /П.Магсаржав/, Мэдээлэл, хяналт шалгалтыг зохицуулах алба /Б.Б.Бат-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.

Гурав. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 30 дугаар зүйлд заасан ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Сав газрын захиргаанд ирүүлэхийг “Заамар гоулд” ХХК /С.Энхтулга/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ДНЯМДОРЖ

Хавсралт 1 Ус ашиглах зөвшөөрөл

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар-13

Улаанбаатар хот

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

“Заамаргоулд” ХХК, гүйцэтгэх захирал С.Энхтулга, утас: 9910-3771, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандийн гудамж, Эм Эс Эн Билдинг, 604 тоот, утас: 7011-1516, 8810-7628, И-мэйл: info@zaamargold.mn, улсын бүртгэлийн дугаар: 9011532045, регистрийн дугаар: 5935539.

2. Төслийн нэр, байршил:

“Заамаргоулд” ХХК-ийн эзэмшлийн Төв аймгийн Заамар сумын “Цагаан чулуут” нэртэй газарт орших MV-012439, MV-000213 дугаартай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй талбай нь Улаанбаатар хотоос баруун хойш 200 км, Төв аймгийн Заамар сумын төвөөс баруун хойш 15 км зайд байрладаг. Туул голын сав газарт хамаарагдана.

3. Төсөл хэрэгжүүлэгч: “Заамаргоулд” ХХК.

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат (X, Y):

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-012439, Талбайн хэмжээ: 152 га.

Уг талбайн солбилцол:

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	104°33'26.58"	48°18'56.82"	15	104°33'34.2"	48°18'17.57"
2	104°33'26.63"	48°18'51.20"	16	104°33'34.05"	48°18'35.05"
3	104°33'29.06"	48°18'51.21"	17	104°33'37.44"	48°18'35.06"
4	104°33'29.15"	48°18'41.19"	18	104°33'37.41"	48°18'40.29"
5	104°33'24.78"	48°18'51.16"	19	104°33'43.02"	48°18'40.29"
6	104°33'24.97"	48°18'17.53"	20	104°33'43.02"	48°18'33.83"
7	104°33'28.38"	48°18'17.54"	21	104°34'01.02"	48°18'33.83"
8	104°33'28.42"	48°18'12.36"	22	104°34'01.01"	48°17'51.82"
9	104°33'32.78"	48°18'12.38"	23	104°34'16.00"	48°17'51.82"
10	104°33'32.91"	48°17'58.14"	24	104°34'16.00"	48°17'22.83"
11	104°33'42.60"	48°17'58.14"	25	104°33'46.01"	48°17'22.83"
12	104°33'42.48"	48°18'12.42"	26	104°33'46.01"	48°17'51.82"
13	104°33'38.61"	48°18'12.40"	27	104°33'21.00"	48°17'51.82"
14	104°33'38.57"	48°18'17.58"	28	104°33'21.02"	48°18'56.82"

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-000213, Талбайн хэмжээ: 26.59 га.

Уг талбайн солбилцол:

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	104°33' 34.05"	48°18' 35.05"	8	104°33' 32.79"	48°18' 12.38"
2	104°33' 34.2"	48°18' 17.57"	9	104°33' 28.42"	48°18' 12.36"
3	104°33' 38.57"	48°18' 17.58"	10	104°33' 28.38"	48°18' 17.54"
4	104°33' 38.61"	48°18' 12.41"	11	104°33' 24.97"	48°18' 17.53"
5	104°33' 42.48"	48°18' 12.42"	12	104°33' 24.79"	48°18' 40.26"
6	104°33' 42.6"	48°17' 58.18"	13	104°33' 37.4"	48°18' 40.26"
7	104°33' 32.91"	48°17' 58.14"	14	104°33' 37.44"	48°18' 35.06"

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт:

Алтны гүний дарагдмал шороон ордыг ил аргаар олборлон, угаан баяжуулах.

6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/:



Хавсралт 2 Ус ашиглах дүгнэлт

Уурхайн олборлолтод ажиллуулах техник:

DOOSAN DX 800 маркийн эксковатор 3 ш
 DOOSAN DX500 маркийн эксковатор 1 ш
 HOWO 371 маркийн автосамосвал 9 ш
 KOMATSU D275 маркийн бульдозер 1 ш
 DOOSAN SD300 маркийн утгуурт ачигч 2 ш

Баяжуулах боловсруулах үйлдвэрт ажиллуулах тоног төхөөрөмж:

СБ-60 маркийн хүрдэт шигшүүр 1 ш /орос/
 СКО-2 маркийн сэгсрэх ширээ (гравитаци) 1 ш /АНУ/
 хоригт цорго (гравитаци) 1 ш /монгол/
 Д-320-50 маркийн динамик насос 1 ш /орос/

Тус уурхайн алт гарган авах технологи нь элс угаан баяжуулах цехэд скрубберээр элсийг угаан ангилаад шлюзээр баяжуулан, гарсан баяжмалыг сэгсрэх ширээгээр баяжуулж, шлихийн алтыг гарган авна.

2022 онд 58 хүн хоногт 2 ээлж 20 цагаар, 270 хоног ажиллана. Элсийг угаах төхөөрөмжийн цагийн хүчин чадал 60.0 м³ (2022 оны АҮАТ-ний 12х, Маягт-7).

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:

2022 онд 1,781.69 мян.м³ хөрс хуулж, 49.23 мян.м³ элс олборлон баяжуулж, 29.6 кг алт гарган авч борлуулна. Биологийн нөхөн сэргээлтийг 1.5 га-д хийж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1000 ш мод тарина.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/:

Унд, ахуйн болон үйлдвэрлэлийн технологи, зам, талбайн тоосжилт дарах, биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усыг зөвшөөрлийн талбайд гаргасан “Юбиксолюшн” ХХК-ийн эзэмшлийн өрөмдмөл 3 худгаас хангадаг.

Усны газраас 2021.08.11-ний өдрийн 116 дугаартай гаргасан усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд “Заамаргоулд” ХХК-ийн хэрэгжүүлэх “Цагаан чулуут” нэртэй алтны шороон ордыг ил аргаар олборлох төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах унд, ахуйн усыг өөрийн эзэмшлийн худгаас, технологийн болон бусад хэрэглээнд шаардагдах усыг Туул голоос хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна гэсэн.

Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Төв аймгийн Заамар сумын Хайлааст 3-р багийн нутагт үйл ажиллагаа явуулж буй ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудад 2021.08.18-20-ны өдрүүдэд хяналт шалгалт хийж, Усны газарт 2021.10.09-ний өдрийн 406 дугаартай ирүүлсэн албан бичигт “Заамаргоулд” ХХК нь Туул голын сав газрын захиргаанаас Туул голоос ус ашиглах зөвшөөрөл авсан ч баяжуулах үйл ажиллагаандаа Туул голоос ус аваагүй гүний усыг шууд ашигласан, шүүрлийн усан дээр тоолуур суурилуулж баталгаажуулаагүй гэсэн. “Заамаргоулд” ХХК нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайдаа ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулахаас өмнө буюу 2021.04.23-30-ны өдрүүдэд “Юбиксолюшн” ХХК-ийн захиалгаар “Топ атлас дриллинг” ХХК-иар 30-35 м-ийн гүнтэй, 8-11.5 м/сек-ын ундаргатай өрөмдмөл худаг гаргуулсан. Унд, ахуйд хоногт 8.7 м³ усыг хэрэглэнэ.

9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/:

Хаягдлын усан сангийн эзлэхүүн: 21,700.0 м³, тунаах сангийн эзлэхүүн: 13,000 м³, эргэлтийн усан сан-гийн эзлэхүүн: 51,600 м³ (БОННҮТ, 50х).

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/:

№	Уртраг	Өргөрөг	Ундарга (п/с)	Насосны марк	Тоолуурын	
					Марк	Дугаар
1	104°33' 2.72"	48°19'31.65"	11.5	QJ		
2	104°32'59.53"	48°19'32.58"	9.0	QJ		
3	104°33' 1.72"	48°19'32.03"	8.0	QJ		

Худагт тоолуур суурилуулахаар худалдан авсан байгаа.

11. Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр/: —

Эргэлтийн усан сангаас элс угаах төхөөрөмж хүртэл ус дамжуулах хуванцар хоолойн урт 250 м, голч 219 мм, элс угаах төхөөрөмжөөс хаягдлын сан хүртэлх ус дамжуулах хуванцар хоолойн урт 500 м, голч 219 мм.

12. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:

Ахуйн хаягдал бохир усыг бохирын цооногт хуримтлуулж, хөрсөнд нэвчүүлэн зайлуулдаг.

13. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:

“Заамаргоулд” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-000213, MV-012439 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Цагаан чулуут”-ын алтны шороон ордын их гүний хэсэг (хш-1-хш-10)-ийг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг 2021 онд “Ногоон эко мандала” ХХК боловсруулж, батлуулсан.

14. Онцгой нөхцөл:

- Шар усны болон гэнэтийн үерийн ус уурхайн ухлага буюу ашиглалт явуулж буй талбай болон хаягдлын санд орохоос сэргийлэн зохих арга хэмжээ авах;
- Гидрогеологийн судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, шүүрлийн усны тооцоог ашиглалтын жилүүдээр хийлгэх;
- Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны өдрийн дотор Усны газарт ирүүлэх шаардлагатайг анхаарах;
- Хаягдлын усан сан, тунаах сан, эргэлтийн усан сангийн ажлын зураг төслийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, зураг төслийн дүгнэлтийг Усны газраар 2022 онд багтаан гаргуулж, хэрэгжүүлэх.

15. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох:

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм”-ын дагуу тооцоход үйлдвэрлэлийн жилийн хэрэгцээнд:

$49,230.0 \text{ м}^3/\text{жил} \times 4.0 \text{ м}^3/\text{тн} = 196,920.0 \text{ м}^3/\text{жил}$. Элс баяжуулахад шаардагдах жилийн усны хэмжээ

Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал: Элсийг угаах төхөөрөмжийн цагийн хүчин чадал 60.0 м^3 (2022 оны АҮАТ-ний 12х, Маягт-7).

$60.0 \text{ м}^3/\text{цаг} \times 1\text{ш} \times 20 \text{ цаг}/\text{хон} = 1,200.0 \text{ м}^3/\text{хон}$	- хоногт угаах элсний хэмжээ
$1,200.0 \text{ м}^3/\text{хон} \times 4.0 \text{ м}^3 = 4,800.0 \text{ м}^3/\text{хон}$	- хоногт шаардагдах усны хэмжээ
$4,800.0 \text{ м}^3/\text{хон} \times 5 \text{ хон} = 24,000.0 \text{ м}^3$	- эргэлтийн усан санд тогтмол байлгах усны хэмжээ
$49,230.0 \text{ м}^3/\text{жил} : 1,200.0 \text{ м}^3/\text{хон} = 41 \text{ хон}$	- элс угаан баяжуулахад зарцуулах хугацаа
$4,800.0 \text{ м}^3/\text{хон} \times 0.2 \times 41 \text{ хон} = 39,360.0 \text{ м}^3$	- ууршилт, шүүрэлтээр алдагдах усны хэмжээ
$24,000.0 \text{ м}^3 + 39,360.0 \text{ м}^3 = 63,360.0 \text{ м}^3$	- үйлдвэрлэлийн технологид ашиглах нийт усны хэмжээ
$39,000.0 \text{ м}^3 \times 2.0 \text{ л}/\text{м}^2 \times 120 \text{ хон} = 9,360.0 \text{ м}^3$	- зам, талбайн тоосжилт дарахад ашиглах ус
$15,000.0 \text{ м}^3 \times 4.0 \text{ л}/\text{м}^2 \times 9 \text{ удаа} = 540.0 \text{ м}^3$	- биологийн нөхөн сэргээлтэд ашиглах ус
$1,000 \text{ ш мод} \times 45 \text{ л}/\text{ш} \times 9 \text{ удаа} = 405.0 \text{ м}^3$	- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад ашиглах ус
$63,360.0 + 9,360.0 + 945.0 = 73,665.0 \text{ м}^3/\text{жил}$	- жилд ашиглах нийт усны хэмжээ
$58 \text{ хүн} \times 150.0 \text{ л}/\text{хон} \times 270 \text{ хон} = 2,349.0 \text{ м}^3/\text{жил}$	- унд, ахуйн усны жилийн хэрэгцээ

16. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу ажилчдын унд, ахуйн зориулалтаар ашиглах 2,349.0 м³/жил усыг төлбөрөөс чөлөөлнө.

Ашигт малтмал баяжуулахад ашиглах 63,360.0 м³/жил, зам, талбайн тоосжилт дарахад ашиглах 9,360.0 м³, биологийн нөхөн сэргээлт, мод тарихад ашиглах 945.0 м³ газрын доорх усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолд заасан суурь үнэлгээ, 2013 оны 326, 327 дугаар тогтоолд заасан усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ, ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүрийг тус тус үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

Ашигт малтмал олборлон, баяжуулахад усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 9,440.0 \text{ төг/м}^3 \times 0.2 \times 0.8 = 1,510.4 \text{ төг/м}^3$$

9,440.0 төг/м³: Туул голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэ;

20%: 326-р тогтоолын 7.а)-д заасан ашигт малтмал олборлох, баяжуулахад газрын доорх ус ашигласны төлбөрийн хувь;

0.8: 327-р тогтоолд заасан Туул голын сав газарт ашигт малтмал олборлох, баяжуулахад газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр.

$$63,360.0 \text{ м}^3 \times 1,510.4 \text{ төг/м}^3 = 95,698,944.0 \text{ төг}$$

Зам, талбайн тоосжилт дарахад усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 9,440.0 \text{ төг/м}^3 \times 0.2 \times 0.1 = 188.8 \text{ төг/м}^3$$

9,440.0 төг/м³: Туул голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

20%: Засгийн газрын 326-р тогтоолын 4-т заасан авто замын зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ;

0.1: Авто замын зориулалтаар Туул голын сав газарт газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр.

$$9,360.0 \text{ м}^3 \times 188.8 \text{ төг/м}^3 = 1,767,168.0 \text{ төг}$$

Биологийн нөхөн сэргээлт, мод усалгаанд усны нөөц ашигласны төлбөр:

$$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 9,440.0 \text{ төг/м}^3 \times 0.1 \times 0.08 = 75.52 \text{ төг/м}^3$$

9,440.0 төг/м³: Туул голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

10%: Засгийн газрын 326-р тогтоолын 9-д заасан нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн усалгаанд газрын доорх ус ашигласныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ;

0.08: Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн усалгаанд Туул голын сав газарт газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр.

$$945.0 \text{ м}^3 \times 75.52 \text{ төг} = 71,366.4 \text{ төг}$$

$$\text{Нийт төлбөр: } 95,698,944.0 + 1,767,168.0 + 71,366.4 = 97,537,478.4 \text{ төг}$$

/Ерөн долоон сая таван зуун гучин долоон мянга дөрвөн зуун далан найман төгрөг/

17. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар:

- Нөхөн сэлбэлтээр авах усны хэмжээг 30%-иас хэтрүүлэхгүй байх.

18. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө:

- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Туул голын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулж ажиллах;
- Усны тухай хуулийн 30.1.4-т заасны дагуу ундны усны эх үүсвэрийн гүний худаг, эргэлтийн усны шугамыг тоолууржуулан баталгаажуулж, тоолуурын заалтаар усны нөөц



ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 26.3.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх;

- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахгүй байх;
- Туул голоос ус ашигладаг бол Усны тухай хуулийн 30.6-д заасны дагуу голын эрэг, голдирлыг үл хөндөн шахуурга, яндан хоолойгоор усыг дамжуулан авч ашиглах;
- Хаягдал усны дүгнэлтийг тухайн жилийн эхний улиралд багтаан гаргуулах;
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах;
- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх;
- Үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж ажиллах;
